



**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР**

**БОЛОН**

**“ЭРДЭНЭС ЦАГААН СУВАРГА” ХХК, “МОНГОЛЫН АЛТ” (МАК) ХХК-ИЙН**

**ХООРОНД БАЙГУУЛСАН ЦАГААН СУВАРГА ТӨСЛИЙН**

**ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГЭРЭЭ**

---

Улаанбаатар хот

ЭХ СУРВАЛЖ: [WWW.ILTODGEREE.MN](http://WWW.ILTODGEREE.MN)

## ГЭРЭЭНИЙ АГУУЛГА

Нэгдүгээр зүйл.	Ерөнхий зүйл, гэрээ байгуулах үндэслэл
Хоёрдугаар зүйл.	Гэрээний зорилго, хугацаа
Гуравдугаар зүйл.	Төслийн компанийн үйл ажиллагаа, хөрөнгө оруулалт
Дөрөвдүгээр зүйл.	Татварын орчин
Тавдугаар зүйл.	Татварын бус хөрөнгө оруулалтын дэмжлэг
Зургаадугаар зүйл.	Хүн амын эрүүл мэнд, байгаль орчинд нөлөөлөх байдал, сөрөг нөлөөллийг бууруулах арга зам, шийдлийн тухай
Дэллоодугаар зүйл.	Бүс нутгийн хөгжилд оруулах хувь нэмэр
Наймдугаар зүйл.	Дэд бүтэц, газрын харилцаа
Есдүгээр зүйл.	Хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөр эрхлэлт
Аравдугаар зүйл.	Засгийн газрын эрх, үүрэг
Арван нэгдүгээр зүйл.	Төслийн компанийн эрх, үүрэг
Арван хоёрдугаар зүйл.	Хөрөнгө оруулагчийн эрх, үүрэг
Арван гуравдугаар зүйл.	Гэрээ дуусгавар болох, цуцлах
Арван дөрөвдүгээр зүйл.	Давагдашгүй хүчин зүйл
Арван тавдугаар зүйл.	Маргаан шийдвэрлэх
Арван зургаадугаар зүйл.	Бусад
Арван долоодугаар зүйл.	Нэр томъёоны тодорхойлолт

Энэхүү Хөрөнгө оруулалтын гэрээ (цаашид "Гэрээ" гэх)-г Монгол Улсын Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 20 дугаар зүйл, Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 2 дугаар сарын 21-ний өдрийн 52 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах журмыг үндэслэн

**Нэг талаас:**

Монгол Улсын Засгийн газар (цаашид "Засгийн газар" гэх), түүнийг бүрэн эрхтэй төлөөлж Засгийн газрын гишүүн, Уул уурхайн сайд Р.Жигжид

**Нөгөө талаас:**

- "Эрдэнэс Цагаан Суварга" ХХК (цаашид "Төслийн компани" гэх), түүнийг бүрэн эрхтэй төлөөлж "Эрдэнэс Цагаан Суварга" ХХК-ийн Гүйцэтгэх захирал Г.Цогт;

- "Монголын Алт" (МАК) ХХК (цаашид "Хөрөнгө оруулагч" гэх), түүнийг бүрэн эрхтэй төлөөлж "Монголын Алт" (МАК) ХХК-ийн Ерөнхийлөгч Б.Нямтайшир

нар (цаашид Засгийн газар, Төслийн компани, Хөрөнгө оруулагч нарыг хамтад нь "Талууд" гэх) 2015 оны 10 дугаар сарын 13-ны өдөр Улаанбаатар хотноо байгуулав.

**Нэг. Ерөнхий зүйл, гэрээ байгуулах үндэслэл**

- 1.1 Дорноговь аймгийн Мандах сумын нутагт орших Цагаан суваргын ордыг түшиглэн Хөрөнгө оруулагч нь хөвүүлэн баяжуулах, дэвшилтэт технологи бүхий "Цагаан суваргын зэс-молибдений уулын баяжуулах үйлдвэр" (цаашид "Цагаан суваргын үйлдвэр" гэх) төсөл (цаашид "Цагаан суваргын төсөл" эсвэл "Төсөл" гэх)-ийг 2001 оноос хэрэгжүүлж эхэлсэн.
- 1.2 Төслийг хэрэгжүүлэх Техник, эдийн засгийн үндэслэл /цаашид "ТЭЗҮ" гэх/-ийг олон улсад мөрддөг стандартын дагуу Хөрөнгө оруулагч компани захиалан боловсруулж, Уул уурхайн яам болон Ашигт малтмалын газрын хамтарсан Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн өргөтгөсөн хурлаар 2013 оны 4 дүгээр сарын 10-ны өдөр хэлэлцүүлж дүгнэлт гаргуулсан.
- 1.3 Улс орны нийгэм, эдийн засгийн урт хугацааны тогтвортой хөгжилд онцгой ач холбогдол бүхий Цагаан суваргын төслийн батлагдсан ТЭЗҮ-ийн дагуу санхүүжилтийн хэмжээ нь **1,031.0 сая** ам.доллар буюу **1,963.0 тэрбум** төгрөг болох тул Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх заалтад тусгагдсан Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах нөхцөл, шаардлагыг бүрэн хангаж байгаа.
- 1.4 Төслийн зураг төсөл, үндсэн тоног төхөөрөмжийн нийлүүлэлт болон төслийн менежментийг АНУ-ын "Эф Эл Смит Солт Лэйк Сити инк" /FLSmith Salt Lake City Inc./ компани, үйлдвэрийн барилгын ажил, тоног төхөөрөмжийн угсралтыг БНХАУ-ын "Жиансу Хэнгюанг Интернэйшнл Инженеринг Ко.лтд" /Jiangsu Hengyuan International Engineering Co.,Ltd/ компани гэрээний үндсэн дээр гүйцэтгэж байгаа.
- 1.5 Монгол Улсын Их Хурлын 2014 оны 7 дугаар сарын 01-ний өдрийн 54 тоот тогтоолоор Цагаан суваргын ордод төр хувь эзэмших шаардлагагүй гэж шийдвэрлэсэн.
- 1.6 Хөрөнгө оруулагч нь 2014 оны 4 дүгээр сарын 02-ны өдрөөс Цагаан суваргын төслийн үйл ажиллагааг тусгаарлаж, өөрийн 100% эзэмшлийн

“Эрдэнэс Цагаан Суварга” ХХК-ийг үүсгэн байгуулсан. Цаашид Төслийг “Эрдэнэс Цагаан Суварга” ХХК хэрэгжүүлнэ.

1.7 Дорноговь аймгийн Мандах сумын нутаг Сэрвэн сухайт нэртэй 132 гектар талбай бүхий зэс-молибдений ордод хамаарах ашигт малтмалын 9630А тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийг Хөрөнгө оруулагч эзэмшиж байгаад 2014 оны 4 дүгээр сарын 08-ны өдрийн Ашигт малтмалын газрын Кадастрын хэлтсийн даргын 131 тоот шийдвэрээр Төслийн компанид шилжүүлсэн.

1.8 Хөрөнгө оруулалтын гэрээний зохицуулалтад хамаарах хуулийн этгээдийн оноосон нэр, улсын бүртгэлийн болон татвар төлөгчийн гэрчилгээний дугаар, хаяг:

“Эрдэнэс Цагаан Суварга” хязгаарлагдмал хариуцлагатай компани, Монгол Улсад үүсгэн байгуулагдсан, улсын бүртгэлийн дугаар 9011465103, регистрийн дугаар 5824826, татвар төлөгчийн дугаар 5824826, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 1-р хороо, 19 хороолол, Чингисийн өргөн чөлөө, Төв байр 44 тоот.

1.9 Хөрөнгө оруулагч компанийн нэр, бүртгэл, хаяг:

“Монголын Алт” (МАК) хязгаарлагдмал хариуцлагатай компани, Монгол Улсад үүсгэн байгуулагдсан, улсын бүртгэлийн дугаар 9011071054, регистрийн дугаар 2095025, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 1-р хороо, 19 хороолол, Чингисийн өргөн чөлөө, Төв байр 44 тоот.

#### Хоёр. Гэрээний зорилго, хугацаа

2.1. Хөрөнгө оруулалтын тухай хуулийн хүрээнд Засгийн газраас Төслийн компанид эрх зүйн баталгаа олгох, татварын болон үйл ажиллагааны орчинг тогтворжуулах, хөрөнгө оруулалтын хэмжээ, эх үүсвэр, хугацаа, үе шатыг тодорхойлох, татварын болон татварын бус, мөн зохицуулалтын дэмжлэг үзүүлэх, үйлдвэрлэх, борлуулах бүтээгдэхүүний хэмжээг тодорхойлох, байгаль орчинд нөлөөлөх байдал, дэд бүтцийн ба бус нутгийн хөгжил, ажлын байр шинээр бий болгохтой холбогдон үүсэх харилцаанд Талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхойлон зохицуулахад энэхүү Гэрээний зорилго оршино.

2.2. Энэхүү Гэрээ нь Талууд гарын үсэг зурж баталгаажуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж, Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3-т заасны дагуу 27 (хорин долоо) жилийн хугацаанд хүчинтэй байна.

#### Гурав. Төслийн компанийн үйл ажиллагаа, хөрөнгө оруулалт

3.1. Төслийн компанийн хэрэгжүүлж буй Цагаан суваргын үйлдвэр дээд хүчин чадлаараа ажиллахад жилдээ 14.6 сая тонн хүртэл хүдэр боловсруулж, 310,000 тонн зэсийн, 4,000 тонн молибдений баяжмал үйлдвэрлэнэ.

3.2. Үйлдвэрлэлийн үйл ажиллагаа нь байгаль орчинд ээлтэй, эдийн засгийн үр ашигтай байна.

3.3. Цагаан суваргын төслийн нийт хөрөнгө оруулалт 1,031.0 сая ам.доллар буюу 1,963.0 тэрбум төгрөг болж байгаа бөгөөд Хөрөнгө оруулагч нь дараах хуваарийн дагуу хөрөнгө оруулалт хийнэ. Төслийн хэрэгжилтийн явцад

Хөрөнгө оруулагч нь шаардлагатай тохиолдолд тухайн жилийн хөрөнгө оруулалтын хэмжээнд өөрчлөлт оруулж болно.

Хөрөнгө оруулалтын хугацаа (оноор)	Хөрөнгө оруулалтын хэмжээ (сая ам.доллар)
2001-2015 буюу өмнө хийсэн хөрөнгө оруулалт	344
2016-2017 он	255
2017-2018 он	285
2018-2019 он	66
2019-2020 он	28
2020 он	53
<b>Нийт</b>	<b>1,031</b>

Цагаан суваргын төслийн хөрөнгө оруулалтын зориулалт, задаргаа:

Ил уурхай	163.2
Баяжуулах үйлдвэр	627.4
Дэд бүтэц	91.3
Бусад	149.1
<b>Нийт</b>	<b>1,031.0 сая ам.доллар</b>

Хөрөнгө оруулагч нь Гэрээ байгуулагдсан өдрийг хүртэл нийт 344.0 сая ам.доллар буюу төгрөгийн ам.доллартай харьцах түүхэн ханшийг 1,724.0 (нэг мянга долоон зуун хорин дөрөв) төгрөгөөр тооцон хөрвүүлэхэд 593.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг хийсэн. Хүлээгдэж буй хөрөнгө оруулалт болох 687.0 сая ам.долларыг энэхүү Гэрээ байгуулагдсан өдрийн Монгол Банкны ханшаар тооцоход 1,370.0 тэрбум төгрөг болно. Дараах эх үүсвэрүүдийн аль боломжит хувилбараас санхүүжилт хийнэ. Үүнд:

- 3.3.1 2012 оны 10 дугаар сарын 09-ний өдөр Хөрөнгө оруулагч болон Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк хооронд байгуулж, нэмэлт өөрчлөлт оруулсан 400 сая ам.долларын зээлийн гэрээ, 2013 оны 6 дугаар сарын 19-ний өдөр Хөрөнгө оруулагч болон ХБНГУ-ын "Ди И Жи" (DEG-Deutsche Entwicklungsgesellschaft) банктай байгуулсан 50 сая ам.долларын зээлийн гэрээний дагуу олгогдох үлдэгдэл санхүүжилт;
- 3.3.2 2011 оны 10 дугаар сарын 13-ны өдөр Улаанбаатар хотноо байгуулсан "Ашигт малтмал, аж үйлдвэр, технологийн салбарт хамтран ажиллах ХБНГУ-ын Засгийн газар болон Монгол Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр"-ийн 6.2-т заасан Монгол Улсад ашигт малтмал боловсруулах үйлдвэрлэл байгуулахыг дэмжих зорилгоор олгох ХБНГУ-ын Засгийн газрын баталгаа, зориулалтыг нь заагаагүй санхүүжилтийн зээл;
- 3.3.3 Төслийн компанид шинэ хөрөнгө оруулагчаас хувьцаа эзэмших байдлаар оруулах хөрөнгө оруулалт;
- 3.3.4 Олон улсын худалдан авагчид Цагаан суваргын төслийн зэсийн баяжмалыг урьдчилан худалдах замаар хийх оффтэйк санхүүжилт;
- 3.3.5 Хөрөнгө оруулагчаас оруулах хөрөнгө оруулалт;



### 3.3.6 Бусад.

- 3.4. Төслийн компани нь үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ зах зээлийн үнээр худалдан борлуулах, тээвэрлэх, экспортлох ба хуулиар хориглоогүй бусад үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын дагуу явуулж, олсон орлогоо чөлөөтэй захиран зарцуулах эрхтэй.
- 3.5. Төслийн компани нь тухайн жилд үйлдвэрлэх бүтээгдэхүүнийхээ хэмжээг Ашигт малтмалын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.6.2-т заасны дагуу уулын ажлын батлагдсан төлөвлөгөөгөөр тодорхойлно.
- 3.6. Төслийн компанийн олборлосон, баяжуулсан бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээг Гэрээ байгуулах өдөр хүчин төгөлдөр үйлчилж буй Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т заасны дагуу тооцно.

### Дөрөв.Татварын орчин

- 4.1. Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.4-т заасны дагуу энэхүү Гэрээний 4.3-т заасан татварын орчин Гэрээний нийт хугацаанд Төслийн компанийн хувьд тогтвортой байна.
- 4.2. Төслийн компани нь зөвхөн энэхүү Гэрээ байгуулсан өдөр хүчин төгөлдөр үйлчилж байсан Татварын ерөнхий хуулийн 7 дугаар зүйлд заасан нэр төрөл, ангиллын татваруудыг төлөх бөгөөд шинээр хууль батлах, хууль тогтоомжид нэмэлт оруулах замаар бий болгосон татвар, мөн Тогтворжуулсан татвартай адилтгах зорилгоор бий болгосон татварыг төлөх үүрэг хүлээхгүй.
- 4.3. Засгийн газар нь дор дурьдсан татвар, төлбөрийг Гэрээ байгуулсан өдөр хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжид заасан хувь хэмжээ, аргачлал (цаашид **"Тогтворжуулсан татварын хувь хэмжээ"** гэх)-аар тооцож ногдуулахаар энэ Гэрээний хугацаанд тогтворжуулна. Үүнд:
  - 4.3.1. Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар;
  - 4.3.2. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр /роялти/;
  - 4.3.3. Гаалийн албан татвар;
  - 4.3.4. Нэмэгдсэн өртгийн албан татвар.
- 4.4. Тогтворжуулсан татвараас бусад татварыг үл ялгаварлах зарчмаар Төслийн компанид ногдуулна.
- 4.5. Гэрээ хүчин төгөлдөр байх хугацаанд татварын хууль тогтоомжид өөрчлөлт орсноор Гэрээний 4.3-т заасан Тогтворжуулсан албан татвар, төлбөрийн хувь хэмжээ буурах тохиолдолд Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасны дагуу Төслийн компани уг өөрчлөлтөд хамаарах ба нэмэгдүүлэх өөрчлөлт орсон тохиолдолд хамаарахгүй.
- 4.6. Татварын буурсан хувь хэмжээ нь нэмэгдсэн тохиолдолд Төслийн компани нь Гэрээ байгуулах үеийн Тогтворжуулсан татварын хувь хэмжээг мөрдөнө.
- 4.7. Төслийн компанийн үйл ажиллагааны зардлыг Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т заасны дагуу албан татвар ногдох орлогоос хасах, тооцох аргачлал нь энэхүү Гэрээ



байгуулагдсан өдөр үйлчилж буй хууль тогтоомжийн дагуу Гэрээний хугацаанд тогтвортой мөрдөгдөнө.

- 4.8. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.16-д заасны дагуу Төслийн компанийн экспортод гаргасан уул уурхайн бүтээгдэхүүнийг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлнө.
- 4.9. Төслийн компанийн татварын тайлангаар гарсан алдагдлыг Гэрээ байгуулагдсан өдөр хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль, тогтоомж, журмын дагуу дараагийн 8 /найм/ хүртэлх жилийн албан татвар ногдуулах орлогоос дараалан хасч тооцно. Албан татвар ногдуулах орлогоос жил бүр хасагдах алдагдлын хэмжээ нь тухайн жилийн албан татвар ногдуулах орлогоос хэтрэхгүй.
- 4.10. Төслийн компанийн нэг жилээс дээшхи хугацаанд ашиглах хөрөнгийн элэгдэл хорогдлын шимтгэл, хөрөнгийн ангиллыг дараах байдлаар тооцно.

№	Үндсэн хөрөнгийн бүлэг	Ашиглах хугацаа /жил/	Элэгдэл тооцох арга	Хөрөнгийн ангилал
1	Барилга байгууламж	40	Шулуун шугамын аргаар	
2	Машин механизм, техник, тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл	10	Шулуун шугамын аргаар	Барилга, байгууламж, уурхай болон уурхайн дэд бүтцэд суурилуулсан машин механизм, тоног төхөөрөмж
3	Компьютер, түүхий эд анги, программ хангамж	3	Шулуун шугамын аргаар	
4	Ашиглалтын хугацаа нь тодорхойгүй биет бус хөрөнгө	10	Шулуун шугамын аргаар	
5	Ашиглалтын хугацаа нь тодорхой биет бус хөрөнгө. /Үүнд ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл хамаарна/	Хүчин төгөлдөр байх хугацаанд	Шулуун шугамын аргаар	
6	Бусад үндсэн хөрөнгө	10	Шулуун шугамын	

V J. J.

			аргаар	
7	Үйлдвэрлэл, технологийн паркийн удирдлага, нэгжийн үйлдвэрлэл, технологийн парк доторхи барилга, байгууламж	20	Шулуун шугамын аргаар	
8	Үйлдвэрлэл, технологийн паркийн удирдлага, нэгжийн үйлдвэрлэл, технологийн парк доторхи үйлдвэрлэлийн зориулалттай машин, механизм, техник, тоног төхөөрөмж	3	Шулуун шугамын аргаар	

- 4.11. Энэхүү Гэрээ байгуулагдсан өдрөөс өмнө Цагаан суварга төслийг санхүүжүүлэх зорилгоор Хөрөнгө оруулагчийн санхүүгийн балансад тусгагдсан боловч үйл ажиллагааны үр дүнгийн тайланд тусгагдаагүй зардлыг Төслийн компанийн албан татвар ногдох орлогоос хасч тооцно.
- 4.12. Төсөлд зориулан Хөрөнгө оруулагч болон Төслийн компанийн авч ашигласан зээлийн хүүгийн төлбөрийг албан татвар ногдох орлогоос хасч тооцно.
- 4.13. Засгийн газрын 2015 оны 190 дүгээр тогтоолын дагуу Цагаан суваргын төслийн бүтээн байгуулалтын ажилд зориулан Хөрөнгө оруулагч, Төслийн компанийн импортолсон, цаашид импортоор оруулж ирэх техник, тоног төхөөрөмж, түүний иж бүрдэлд ногдох гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварыг гаалийн бүрдүүлэлт хийснээс хойш 2 жил хүртэлх хугацаагаар хойшлуулах ба татварын эргэн төлөлтийн хуваарийг Сангийн яамтай байгуулах гэрээгээр зохицуулна.
- 4.14. Энэхүү Гэрээ байгуулагдахаас өмнө Хөрөнгө оруулагч, Төслийн компанийн хийсэн Төслийн үйл ажиллагаанд үл хамаарах аливаа гэрээ, хэлцэл нь энэхүү Гэрээнд хамаарахгүй.

#### Тав. Татварын бус хөрөнгө оруулалтын дэмжлэг

- 5.1 Засгийн газар нь Төслийн компанид дор дурьдсан татварын бус хөрөнгө оруулалтын дэмжлэгийг үзүүлж болно. Үүнд:
- 5.1.1 Газрыг 60 хүртэл жилээр гэрээний үндсэн дээр эзэмшүүлэх, уг хугацааг гэрээний анхны нөхцлөөр нэг удаа 40 хүртэл жилээр сунгах;
- 5.1.2 Төслийн болон дэд бүтцийн барилга угсралтын ажлыг гүйцэтгэхэд Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3 дах хэсэгт заасан дэмжлэг;
- 5.1.3 Гадаадын банк санхүүгийн байгууллагаас Төсөлд зориулж зээл авах тохиолдолд Засгийн газрын боломжит дэмжлэг;
- 5.1.4 Хуульд заасан бусад дэмжлэг.



**Зургаа. Хүн амын эрүүл мэнд, байгаль орчинд нөлөөлөх байдал, сөрөг нөлөөллийг бууруулах арга зам шийдлийн талаар**

- 6.1. Төслийн компани нь Монгол Улсын "Байгаль орчныг хамгаалах тухай" багц хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулна.
- 6.2. Төслийн компани өөрийн эзэмшиж ашиглаж буй газар, тусгай зөвшөөрлийн талбайд Монгол Улсын хууль тогтоомж, стандарт болон олон улсад тавигддаг шаардлагын дагуу байгаль орчныг хамгаалах, техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх ажлыг бүрэн хариуцна.
- 6.3. Төслийн компани байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг эрх бүхий мэргэжлийн байгууллагаар хийлгэж, холбогдох төрийн байгууллагаар баталгаажуулан мөрдөж ажиллана.
- 6.4. Төслийн компани нь байгаль орчны менежментийн төлөвлөгөө болон хөндлөнгийн шинжээчийн тайланг олон нийтэд нээлттэй байлгаж, орон нутгийн иргэдийг холбогдох мэдээллээр хангана.
- 6.5. Төслийн компани нь Цагаан суваргын үйлдвэрийн үйл ажиллагааны үр дагавраас байгаль орчинд учирч буй нөлөөллийн талаар орон нутгийн иргэдтэй зөвлөлдөж холбогдох арга хэмжээг авч ажиллана.
- 6.6. Төслийн компани нь байгаль орчныг хамгаалах чиглэлээр тухайн жилд төсөвлөсөн зардлыг хууль тогтоомжид заасан тусгай дансанд байршуулна.
- 6.7. Төслийн компани нь байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан тухайн жилийн байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээг гүйцэтгэн орон нутгийн комисст хүлээлгэн өгч, дүгнэлт гаргуулна.
- 6.8. Цагаан суваргын үйлдвэрийн үйл ажиллагааны үр дүнд агаар, ус, хөрс, амьтан, ургамал болон газрын хэвлийд ноцтой сөрөг нөлөө үзүүлсэн нь тогтоогдвол Төслийн компани нь түүний үр дагаврыг арилгах, давтан гаргахгүй байх арга хэмжээг авч ажиллана.
- 6.9. Төслийн компани нь хүдрийн ил уурхайн хаалтын менежментийн төлөвлөгөөг боловсруулж ажиллах ба хүдрийн ил уурхайг хаах үед тавигдах шаардлагыг холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмын дагуу бүрэн биелүүлэх үүрэгтэй.
- 6.10. Төслийн компани нь уурхайн хаалтын нөхөн сэргээлтийн дараа талбайг эдийн засгийн эргэлтэд оруулах талаар судалгаа, шинжилгээ хийж төлөвлөгөө батлуулан ажиллана.
- 6.11. Төслийн компани нь төслийг хэрэгжүүлэх явцад биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалалтын төлөвлөгөө боловсруулж, орон нутагтай хамтран ажиллана.

**Долоо. Бүс нутгийн хөгжилд оруулах хувь нэмэр**

- 7.1. Орон нутгийн засаг захиргааны зүгээс хэрэгжүүлж буй нийгэм, эдийн засгийн хөгжлийн бодлого, үйл ажиллагааг Төслийн компани дэмжиж ажиллана.
- 7.2. Төслийн компани нь бүс нутаг болон орон нутагт хэрэгжүүлэх нийгэм, эдийн засгийн хөгжлийн хөтөлбөр, үйл ажиллагаагаа ил тод, хариуцлагатай, олон нийтийн оролцоог хангах зарчмын үндсэн дээр явуулна.
- 7.3. Төслийн компани нь Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу нутгийн захиргааны байгууллагатай гэрээ байгуулна.

- 7.4. Төслийн компани нь Дорноговь аймгийн Мандах сум болон тус аймгийн бусад сумдын иргэдийг сургах, ажлын байраар хангах талаар тэргүүн ээлжинд анхаарна.
- 7.5. Төслийн компани нь Засгийн газрын "Шинэ сумын төв" хөтөлбөрийн хүрээнд Дорноговь аймгийн Мандах сумын төвийн захиргааны байр, эмнэлэг, сургууль, дотуур байр, цэцэрлэг, соёлын төвийг өөрийн хөрөнгөөр барьж байгуулна.
- 7.6. Төслийн компани нь нутгийн өөрөө удирдах байгууллагатай хамтран байгуулсан "МАК Дэд Сан"-гийн үйл ажиллагааг орон нутгийн ард иргэдэд нээлттэй, ил тод явуулна.
- 7.7. Цагаан суваргын үйлдвэрийн үйл ажиллагаанд шаардлагатай хангамж, бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг нийлүүлэх жижиг дунд үйлдвэрлэлийн төсөл, хөтөлбөрийг "МАК Дэд Сан"-аар дамжуулан дэмжиж ажиллана.
- 7.8. Говь нутгийн мал аж ахуйн үндэс болсон тэмээн сүргийн тоо толгойг нэмэгдүүлэх, малчин ард иргэдийн амьжиргаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор Хөрөнгө оруулагчийн санаачилсан "Ботгонд бонус" хөтөлбөрийг Төслийн компани энэхүү гэрээний хугацаанд үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
- 7.9. Төслийн компани нь орон нутгийн ард иргэдийн ёс заншил, өв уламжлалыг хүндэтгэж ажиллана.
- 7.10. Төслийн компани нь үйлдвэрлэлийн хэрэгцээ, зориулалт, шаардлага, чанарын үзүүлэлтийг хангаж байгаа тохиолдолд бараа, материал, техникийн сэлбэг, эд ангийг Монголын үндэсний компани, аж ахуйн нэгжээр гүйцэтгүүлэхэд давуу эрх олгож ажиллана.

#### Найм. Дэд бүтэц, газрын харилцаа

- 8.1. Засгийн газар нь эрчим хүчний холбогдох зөвшөөрлийг Төслийн компанид аль болох шуурхай олгох бөгөөд зөвшөөрлийг Эрчим хүчний тухай болон бусад холбогдох хууль тогтоомж, дүрэм журмаар зөвшөөрсөн хамгийн дээд хугацаагаар олгож, сунгуулах эрхтэйгээр энэхүү Гэрээний хүчинтэй хугацаанд олгоно.
- 8.2. Цагаан суваргын үйлдвэрийн хэрэгцээ, шаардлага, бүтээн байгуулалтын ажлыг хугацаанд нь гүйцэтгэхийн тулд эрчим хүчний хамгийн зохистой, найдвартай эх үүсвэрээр хангах талаар Засгийн газар, Хөрөнгө оруулагч, Төслийн компани хамтран ажиллана.
- 8.3. Засгийн газар Цагаан суваргын үйлдвэрийг эрчим хүчээр хангахдаа эрчим хүчний эх үүсвэр, үнэ, тариф, төлбөр, хураамжийг үл ялгаварлах зарчимд тулгуурлан тогтооно.
- 8.4. Монгол Улсын Эрчим хүчний тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх заалт, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 1999 оны 7 дугаар сарын 6-ны өдрийн 05 тоот зөвлөмжийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын 1999 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 64 тоот тогтоолыг үндэслэн Оюутолгой-Цагаан суваргын 220 кВ-ийн өндөр хүчдэлийн агаарын шугам, дэд өртөө нь "Өмнөд бүсийн цахилгаан дамжуулах сүлжээ" ТӨХК-ийн мэдэлд байна.

- 8.5. Төслийн компани нь дэд бүтцийн хөтөлбөрийн хүрээнд нисэх буудал, хөөрөх буух зурвасыг шинээр барьж ашиглалтад оруулах ба холбогдох зөвшөөрлийг Засгийн газар, түүний харъяа төрийн байгууллага хууль тогтоомжийн дагуу шуурхай шийдвэрлэнэ.
- 8.6. Төслийг хэрэгжүүлэх хугацаанд Төслийн компани нь өөрийн хөрөнгөөр усны нөөц олж илрүүлвэл Засгийн газар түүнийг ашиглах эрхийг олгох бөгөөд тухайн усны нөөцөөс сум, орон нутгийн малчин өрхүүдийн ахуйн хэрэгцээнд ашиглуулна.
- 8.7. Төсөлд шаардагдах усны хэрэгцээг хангах зорилгоор Цагаанцавын гүний усны нөөцийг ашиглах шаардлага гарсан тохиолдолд байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага холбогдох хууль тогтоомжийн дагуу үйлдвэрийн болон ахуйн зориулалтаар ус ашиглуулах дүгнэлт гаргах бөгөөд ус ашиглуулах зөвшөөрөл олгох, гэрээ байгуулахад Засгийн газар дэмжлэг үзүүлнэ.
- 8.8. Төслийн компани нь өөрийн эзэмшлийн дэд бүтцийн тодорхой байгууламж, түүний үйлчилгээг Цагаан суваргын төслийн үйл ажиллагаанд саад учруулахгүй байх нөхцөлд бүс нутгийн хэрэгцээнд зориулан иргэн, аж ахуйн нэгж байгууллага, орон нутгийн болон бусад гуравдагч этгээдэд гэрээгээр ашиглуулж болно.
- 8.9. Төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай үйлдвэрлэлийн үндсэн ба туслах байгууламж, ахуйн болон дэд бүтцийн зориулалт бүхий газруудыг эзэмшиж, ашиглахтай холбогдсон зөвшөөрлийг төрийн захиргааны болон орон нутгийн өөрөө удирдах байгууллагуудаас Төслийн компанид олгоход Засгийн газар дэмжлэг үзүүлнэ.
- 8.10. Төслийн компани нь үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд нэмэлт газар шаардагдах тохиолдолд газар эзэмших, ашиглах хүсэлтийг төрийн захиргааны болон орон нутгийн өөрөө удирдах байгууллагуудад гаргах ба Засгийн газар дэмжлэг үзүүлнэ.
- 8.11. Уул уурхайн зориулалтаар ашигласан газрыг нөхөн сэргээхтэй холбоотой бүх асуудлыг Газрын тухай хууль, Ашигт малтмалын тухай хууль, Газар ашиглах гэрээ, Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайлан, мөн энэхүү Гэрээнд тусгайлан заасны дагуу Төслийн компани бүрэн хариуцна.
- 8.12. Төслийн компанийн эзэмшиж, ашиглаж буй газраас тусгай хэрэгцээ, тусгай хамгаалалт, нөөцөд тодорхой хэмжээний газрыг авахтай холбоотой харилцааг Газрын тухай хууль, тогтоомжийн дагуу зохицуулж, холбогдох нөхөн олговрыг олгоно.
- 8.13. Хуульд заасан хугацаа дуусгавар болохоос бусад тохиолдолд, мөн Газрын тухай хууль, тогтоомжид заасны дагуу Талууд харилцан тохиролцоогүй бол Төслийн компанийн газар эзэмших, ашиглах эрх хүчин төгөлдөр байна. Газар эзэмших, ашиглах гэрээ дуусгавар болох тохиолдолд тухайн газар дээр байрлах Төслийн компанийн өмчлөлд байгаа үйлдвэр, барилга байгууламж, шугам сүлжээ, хөдлөх, үл хөдлөх хөрөнгийн өмчлөгч нь Төслийн компани хэвээр байна.

- 8.14. Төслийн компани нь улсын болон орон нутгийн чанартай авто зам, дамжуулах хоолой, бусад тээврийн байгууламжийг барьж байгуулахдаа Монгол Улсын хууль тогтоомж, дүрэм журмыг дагаж мөрдөх бөгөөд Монгол Улсын авто зам, тээврийн нэгдсэн сүлжээ, хөгжлийн стратегитэй уялдуулна.
- 8.15. Засгийн газар нь Газрын төлбөрийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.10-д заасан нөхцлийг хангасан тохиолдолд Төслийн компанид газрын төлбөрийн хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлнэ.

#### Ес. Хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөр эрхлэлт

- 9.1 Төслийн компани нь Цагаан суваргын үйлдвэр, хүдрийн ил уурхайд ажиллах инженер техникийн ажилтан, ажиллагсдыг сургалтын тусгай төлөвлөгөөний дагуу дотоод, гадаадын их, дээд сургууль, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүдэд давтан сургах ба мэргэжилтэй ажилтан шинээр бэлтгэнэ.
- 9.2 Төслийн компанийн нийт ажиллагсдын 10 хүртэлх хувьд хууль, тогтоомжийн дагуу хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл авсны үндсэн дээр гадаадын ажиллах хүч, мэргэжилтэн ажиллуулж болно.
- 9.3 Цагаан суваргын төслийн барилга бүтээн байгуулалт, туршилт тохиргоо, зүгшрүүлэлтийн ажил, Операторын үйлчилгээ үзүүлэх /Operation and Maintenance(O&M)/ гэрээний дагуу зайлшгүй шаардлагатай гадаад ажиллагсдын Монгол Улсад оршин суух, хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийг Засгийн газар холбогдох хуулийн дагуу олгож, хугацааг сунгахад дэмжлэг үзүүлж ажиллана.

#### Арав. Засгийн газрын эрх, үүрэг

- 10.1 Засгийн газар нь Төслийн компанийн үйл ажиллагаагаа явуулах татварын болон тогтворжуулсан татварын орчинг энэхүү Гэрээ хүчин төгөлдөр хугацаанд тогтвортой байлгах үүргийг хүлээнэ.
- 10.2 Засгийн газар нь энэхүү Гэрээний хэрэгжилтийг хангах, Гэрээнд заасан хамтын зорилтуудад хүрэхийн тулд боломжит бүх арга хэмжээг авч ажиллана.
- 10.3 Энэхүү Гэрээ хүчин төгөлдөр болмогц Засгийн газраас Гэрээний нөхцөл, бусад мэдэгдлийг холбогдох яам, агентлаг, төрийн захиргааны ба орон нутгийн байгууллагуудад хүргүүлнэ.
- 10.4 Засгийн газар нь Төслийн үндсэн болон туслах үйл ажиллагаатай холбоотой эрх, тусгай зөвшөөрлийг холбогдох хууль, журамд зааснаас бусад тохиолдолд гэрээний хүчинтэй хугацаанд цуцлахгүй, хүчингүй болгохгүй.
- 10.5 Энэхүү Гэрээний хугацаанд Төслийн компани, Хөрөнгө оруулагчийн хөдлөх, үл хөдлөх эд хөрөнгө, тэдгээртэй холбоотой эрх, оюуны өмч, тусгай зөвшөөрлийг Засгийн газар хууль бусаар хураан авахгүй, төрийн өмчид шилжүүлэхгүй.

*(Handwritten signature)*

- 10.6 Цагаан суваргын төслийн үйл ажиллагааг хэвийн явуулах үүднээс Хөрөнгө оруулагч болон Төслийн компаниас Засгийн газар, төрийн захиргааны байгууллагад хандан гаргасан шаардлагатай бүхий л эрх, зөвшөөрөл, хүсэлтийг Монгол Улсын хууль тогтоомж, дүрэм журмын дагуу шуурхай шийдвэрлэхэд Засгийн газар дэмжлэг үзүүлнэ.
- 10.7 Төслийн компани, түүний Хөрөнгө оруулагчийн аливаа эд хөрөнгийг хууль бусаар дайчлан авахгүй. Хэрэв Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль, тогтоомжийн дагуу нийтийн ашиг сонирхлын үүднээс дайчлан авах шийдвэр гарсан тохиолдолд Засгийн газар нь Төслийн компани, түүний Хөрөнгө оруулагчид учрах аливаа хохирлыг дайчлан авах үеийн зах зээлийн үнэлгээгээр хамтран тооцож нөхөн олговрыг олгоно.
- 10.8 Түнш орнууд болон бүс нутгийн хэмжээнд Засгийн газраас байгуулах аливаа эдийн засгийн болон худалдааны хэлэлцээрт худалдааг хөнгөвчлөх, тарифын болон тарифын бус саад тотгорыг багасгах арга хэмжээг тусгах замаар Төслийн компанийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг гадаад зах зээлд нэвтрэх боломжийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.
- 10.9 Засгийн Газар нь Хөрөнгө оруулагч, Төслийн компанийн хүсэлтийг үндэслэн санхүүгийн дэмжлэг үзүүлж болно.
- 10.10 Засгийн газар нь энэхүү Гэрээний хэрэгжилтэд хяналт тавих зорилгоор Хөрөнгө оруулагч болон Төслийн компаниас холбогдох мэдээ, тайлан гаргуулах, Төслийн үйлдвэртэй танилцах эрхтэй.

#### Арван нэг. Төслийн компанийн эрх, үүрэг

- 11.1 Цагаан суваргын төсөлд оруулсан Төслийн компанийн хөрөнгө оруулалт нь Монгол Улсын Үндсэн хууль, Хөрөнгө оруулалтын тухай хууль болон бусад хууль тогтоомж, дүрэм журам, Монгол Улсын олон улсын гэрээгээр баталгаажсан эрх зүйн хамгаалалтад байна.
- 11.2 Төслийн компани нь ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайд ашигт малтмал хайх, ашиглах, олборлох, боловсруулах, бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйл ажиллагаа явуулах эрхтэй.
- 11.3 Төслийн компани нь Гэрээний 3.1-т заасан хүчин чадал бүхий үйлдвэрийг барьж байгуулах, Гэрээний 3.3-т заасан хөрөнгө оруулалтыг хийх үүрэгтэй.
- 11.4 Төслийн компани нь энэхүү Гэрээгээр хүлээсэн бүх үүргээ биелүүлнэ.
- 11.5 Төслийн компани нь өөрийн тодорхойлсон менежмент, маркетингийн зарчмын дагуу үйл ажиллагаагаа явуулах эрхтэй.
- 11.6 Хүдрийн ил уурхайд ашиглалтын үр ашигтай технологийг сонгож, хөрс хуулалт, олборлолтын ажилд орчин үеийн, өндөр хүчин чадал, оновчтой шүтэлцээ бүхий техник тоног төхөөрөмжөөр уулын ажлыг явуулж, дэлхийн шилдэг тэргүүний технологийг баяжуулах үйлдвэрт нэвтрүүлнэ.
- 11.7 Төслийн компани нь бэлэн мөнгө, техник, тоног төхөөрөмж, түүхий эд, бараа материал, оюуны болон аж үйлдвэрийн өмчийн эрх зэрэг хөдлөх, үл хөдлөх



- хөрөнгийн бүх хэлбэрээр хөрөнгө оруулалт хийх эрхтэй.
- 11.8 Төслийн компани нь Монгол Улсын болон бусад улсын арилжааны банкинд данс нээж сонгосон валютаараа гадаад гүйлгээг чөлөөтэй, саадгүйгээр хийх эрхтэй.
  - 11.9 Төслийн компанийн нийт гаргасан хувьцааны 33 буюу түүнээс дээш хувийг гадаадын төрийн өмчит хуулийн этгээд эзэмших тохиолдолд Засгийн газраас зөвшөөрөл авна.
  - 11.10 Төслийн компани нь Цагаан суваргын ордыг бусдад барьцаалах, шилжүүлэх тохиолдолд Засгийн газрын эрх бүхий байгууллагад урьдчилан мэдэгдэнэ.
  - 11.11 Төслийн компани нь үйлдвэрлэл эрхлэх явцдаа уурхайн олборлолт, баяжуулалтын технологийн шаардлага хангахгүй нь тогтоогдсон хөрсний овоолго, хаягдал ус, хаягдлын овоолго, завсрын бүтээгдэхүүн зэргээс ашигт малтмал ялган авах, үйлдвэрлэх нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүнийг боловсруулах дотоодын аж ахуйн нэгжүүдийг дэмжиж ажиллана.
  - 11.12 Төслийн компани нь Монгол Улсад өнгөт төмөрлөгийн үйлдвэрийг хөгжүүлэх бодлогыг дэмжиж ажиллана.
  - 11.13 Төслийн компани нь үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж байгаа боловсруулах үйлдвэрт тэргүүн ээлжинд зах зээлийн үнээр нийлүүлэх үүрэгтэй.
  - 11.14 Төслийн санхүүжилтийг шийдвэрлэх зорилгоор үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ урьдчилан худалдах бол Төслийн компанийн олон улсын байгууллага, гадаадын аж ахуйн нэгжийн өмнө хүлээсэн үүрэг нь Гэрээний 11.13 дахь заалтаас давуу эрхтэй байна.
  - 11.15 Төслийн компани нь Засгийн газраас энэхүү Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах, биелүүлээгүйн улмаас өөрт учирсан хохирлоо нэхэмжлэх эрхтэй.
  - 11.16 Төслийн компани нь хөрөнгө оруулалт, Төслийн хэрэгжилтийн талаарх тайланг дараа жилийн нэгдүгээр улиралд багтаан Хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад өгөх үүрэгтэй.
  - 11.17 Төслийн компани нь бүтээгдэхүүнээ урьдчилан худалдах замаар олсон орлого, санхүүжилтийг гадаад улсын банк, санхүүгийн байгууллагад төвлөрүүлэх, зээлдүүлэгчид шууд шилжүүлэх эрхтэй бөгөөд үүнээс бусад тохиолдолд Цагаан суваргын үйлдвэрийн орлогыг Монгол Улсын арилжааны банкинд төвлөрүүлнэ.

#### **Арван хоёр. Хөрөнгө оруулагчийн эрх, үүрэг**

- 12.1 Цагаан суваргын төсөлд оруулсан Хөрөнгө оруулагчийн хөрөнгө оруулалт нь Монгол Улсын Үндсэн хууль, Хөрөнгө оруулалтын тухай хууль болон бусад хууль тогтоомж, дүрэм журам, Монгол Улсын олон улсын гэрээгээр баталгаажсан эрх зүйн хамгаалалтад байна.
- 12.2 Хөрөнгө оруулагч нь Цагаан суваргын төсөлтэй холбоотой өөрийн нэр дээр эзэмшиж байгаа газар эзэмших, ашиглах эрх, хууль тогтоомжийн дагуу олгогдсон бусад зөвшөөрлүүдийг Төслийн компанид шилжүүлнэ.
- 12.3 Энэхүү Гэрээ байгуулагдахаас өмнө Цагаан суваргын төслийн бүтээн байгуулалтад зориулан Хөрөнгө оруулагчийн худалдан авсан бараа



бүтээгдэхүүн, ажил үйлчилгээ, барилга байгууламж, машин техник, тоног төхөөрөмж зэрэг биет болон биет бус хөрөнгө оруулалт, ноу-хауг Төслийн компанийн өмчлөлд шилжүүлнэ.

- 12.4 Хөрөнгө оруулагч нь Төслийн компанид шаардлагатай хөрөнгө оруулалт, санхүүжилтийг татах, эх үүсвэрийг тодорхойлох, үйл ажиллагаанд хяналт тавих эрхтэй.
- 12.5 Хөрөнгө оруулагч нь Засгийн газраас энэхүү Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах, биелүүлээгүйн улмаас өөрт учирсан хохирлоо нэхэмжлэх эрхтэй.
- 12.6 Хөрөнгө оруулагч нь Гэрээний 3.3-т заасан хөрөнгө оруулалтыг хуваарийн дагуу хийнэ.

#### **Арван гурав. Гэрээ дуусгавар болох, цуцлах**

- 13.1. Энэхүү Гэрээ нь дараах тохиолдолд дуусгавар болно. Үүнд:
  - 13.1.1. Гэрээний хүчинтэй хугацаа дууссаны дараа Талууд хугацааг сунгаагүй бол;
  - 13.1.2. Аль нэг тал нь Гэрээг дуусгавар болгох тухай хүсэлт гаргасны дагуу Талууд харилцан тохиролцсон бол;
  - 13.1.3. Цагаан суваргын ордын нөөц дууссан.
- 13.2. Энэхүү Гэрээ дуусгавар болсон нь Төслийн компани, Хөрөнгө оруулагчийн эзэмшиж ашиглаж буй эрх, тусгай зөвшөөрлүүд, Төслийн компани болон Хөрөнгө оруулагчаас Засгийн газар, төрийн байгууллагуудтай байгуулсан бусад гэрээний эрх, үүргийг дуусгавар болгох, хязгаарлах, цуцлах үндэслэл болохгүй.
- 13.3. Төслийн компани, Хөрөнгө оруулагч нь Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд Гэрээг түдгэлзүүлэх, цуцлах эрх Засгийн Газарт байна.
- 13.4. Төслийн компани, Хөрөнгө оруулагч нь Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол Засгийн газар Гэрээг түдгэлзүүлэх, цуцлах, татварын болон татварын бус дэмжлэг, тогтворжуулалтыг хүчингүй болгож нөхөн төлбөр нэхэмжлэхээс өмнө Төслийн компани, Хөрөнгө оруулагч нарт урьдчилан мэдэгдэж үүргийн зөрчлийг арилгах хугацааг 12 (арван хоёр) хүртэл сараар олгоно.
- 13.5. Төслийн компани, Хөрөнгө оруулагч нь Засгийн газраас тавьсан шаардлагыг хүлээн авснаас хойш 1 (нэг) сарын дотор тайлбар, санал, хүсэлт гаргаж болно.
- 13.6. Гэрээний 13.4-т заасан хугацаа нь тухайн үүргийн зөрчлийг арилгахад хүрэлцэхгүй тохиолдолд Төслийн компани, Хөрөнгө оруулагчийн хүсэлтийг харгалзан 12 сар хүртэлх хугацаагаар сунгаж болно.

#### **Арван дөрөв. Давагдашгүй хүчин зүйлс**

- 14.1 Давагдашгүй хүчин зүйлс гэдэгт газар хөдлөлт, хүчтэй салхи, түймэр, аянга, үер, ган, зуд зэрэг байгалийн гамшиг, цацраг идэвхит бодисын хордуулалт, олон улсын шинжтэй хилийн боомт хаагдах, хөдөлмөрийн маргаанаас үүссэн өргөн хэмжээний эмх замбараагүй байдал, нийтийг хамарсан өвчин



тахал, дайн, дайн бүхий байдал, хорио цээр зэрэг нийгмийн онцгой байдал, дэлхийн зах зээлд зэс молибдений үнэ буурч Төслийн компани алдагдалд хүрсэн, санхүү, эдийн засгийн хямралаас шалтгаалан эдийн засгийн боломжит цар хүрээ хумигдсан зэрэг энэхүү Гэрээний аль нэг талын хяналтаас давсан үйлдлийг ойлгоно.

- 14.2 Давагдашгүй хүчин зүйлийн улмаас Талууд нь Гэрээгээр хүлээсэн үүргээ бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн биелүүлээгүй, зохих ёсоор биелүүлж чадаагүй бол тухайн давагдашгүй хүчин зүйлийн хугацаанд аль нэг тал хариуцлага хүлээхгүй.
- 14.3 Давагдашгүй хүчин зүйлийн улмаас үүргээ биелүүлж чадахгүй болсон Тал нь энэ тухай нөгөө талдаа бичгээр шуурхай мэдэгдэх бөгөөд Талууд боломжтой бүх арга хэмжээг авах, шалтгааныг арилгахын төлөө хамтран ажиллана.
- 14.4 Энэхүү Гэрээний аль нэг тал Давагдашгүй хүчин зүйлийн улмаас Гэрээгээр хүлээсэн үүргээ бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн биелүүлээгүй, хойшлуулсан тохиолдолд давагдашгүй хүчин зүйлийн үр дагаврыг арилгах боломжит хугацаа болон тухайн ажлыг эхлүүлэх буюу үргэлжлүүлэхэд шаардагдах бэлтгэл ажлын бодит хугацаагаар Гэрээг сунгана.

#### **Арван тав. Маргаан шийдвэрлэх**

- 15.1 Хэрэв Талуудын хооронд энэхүү Гэрээ, түүний хэрэгжилттэй холбоотой маргаан, санал зөрөлдөөн эсхүл үл ойлголцол (цаашид "Маргаан" гэх) үүссэн тохиолдолд тухайн Тал нь үүсээд буй Маргааныг Гэрээний 15.2-т заасан журмын дагуу шийдвэрлэх тухай мэдэгдэл (цаашид "Маргаан шийдвэрлэх мэдэгдэл" гэх)-ийг нөгөө Талуудад хүргүүлнэ.
- 15.2 Маргааныг эв зүйгээр шийдвэрлэх:
  - 15.2.1 Маргаан шийдвэрлэх мэдэгдлийг хүргүүлснээс хойш ажлын 60 хоногийн дотор Талууд Маргааныг эв зүйгээр шийдвэрлэж чадаагүй бол Маргааныг шийдвэрлэх эрх бүхий төлөөлөгчдийг Талууд томилно.
  - 15.2.2 Эрх бүхий этгээдүүдийг томилсноос хойш ажлын 60 хоногт Маргааныг шийдвэрлэж чадаагүй тохиолдолд Хөрөнгө оруулагч, Төслийн компанийн дээд түвшний удирдлага, Засгийн газрын гишүүнээр ахлуулсан төлөөлөгчид дахин хэлэлцээ хийнэ.
- 15.3 Маргаан шийдвэрлэх мэдэгдлийг анх хүргүүлснээс хойш ажлын 120 хоногийн хугацаанд Талууд нэгдсэн шийдвэрт хүрч чадаагүй бол Маргааныг Монгол Улсын Арбитрын тухай хуулийн дагуу МҮХАҮТанхимын дэргэдэх Монголын Олон Улсын ба Үндэсний Арбитраар шийдвэрлүүлнэ.
- 15.4 Арбитрын шийдвэр нь эцсийнх бөгөөд уг шийдвэрийг Талууд биелүүлнэ.
- 15.5 Гэрээний 15 дугаар зүйлд заасан маргаан шийдвэрлэх заалт нь Гэрээ хүчин төгөлдөр байх хугацаанд, мөн Гэрээний хугацаа дууссаны дараа, эсвэл Гэрээ хугацаанаас өмнө дуусгавар болсны дараа Талуудын хооронд энэхүү Гэрээтэй холбогдсон аливаа маргаанд адил хамаарна.

## Арван зургаа. Бусад

- 16.1. Талууд хэлэлцээ хийж тохиролцсоны үндсэн дээр энэхүү Гэрээгээр хүлээсэн эрх, үүргээ бусдад шилжүүлэх эрхтэй.
- 16.2. Энэхүү Гэрээ нь Засгийн газрын харъяа байгууллага болон гадаад дотоодын иргэд, аж ахуйн нэгжтэй Цагаан суваргын төслийн үйл ажиллагаатай холбоотой гэрээ, санамж бичиг байгуулах Талуудын эрхийг хязгаарлахгүй.
- 16.3. Талууд Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх бүрэн эрх, Гэрээ байгуулах хууль ёсны итгэмжлэлтэй болохоо харилцан баталгаажуулав.
- 16.4. Хэрэв Гэрээний аль нэг заалт тодорхой шалтгаанаар хэрэгжих боломжгүй бол тухайн заалтыг Гэрээнээс тусад нь авч үзэх бөгөөд энэхүү Гэрээний бусад хэсэг хүчин төгөлдөр үйлчилнэ.
- 16.5. Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно.
- 16.6. Гэрээний дагуу аливаа мэдэгдэл, бусад харилцааг Талууд бичгээр үйлдэх бөгөөд тухайн баримт бичгийг биечлэн, эсхүл шуудан, факсаар илгээн, шуудангийн салбарт хүргэснээр тухайн баримт бичгийг зохих ёсоор хүлээлгэн өгсөнд тооцно.
- 16.7. Хөрөнгө оруулалтын гэрээгээр зохицуулагдаагүй аливаа харилцааг Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөж буй хууль тогтоомж, дүрэм журам, Монгол Улсын олон улсын гэрээнд заасны дагуу зохицуулна.
- 16.8. Энэхүү Гэрээг монгол хэл дээр 3 /гурван/ хувь үйлдэж, Талууд тус бүр 1 хувийг хадгална.
- 16.9. Энэхүү гэрээг байгуулснаас хойш зах зээлийн эрэлт хэрэгцээнээс хамааран Цагаан суварга үйлдвэрийн хүчин чадал нэмэгдэх бол Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулна.
- 16.10. Энэхүү гэрээнд Талууд гарын үсэг зурж баталгаажуулсан өдрөөс эхлэн Гэрээ хүчин төгөлдөр болно.

## Арван долоо. Нэр томъёоны тодорхойлолт

Энэхүү Гэрээнд хэрэглэсэн нэр томъёо нь дараах агуулгыг илэрхийлнэ:

- 17.1 “Техник, эдийн засгийн үндэслэл” гэж Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, олон улсад мөрддөг стандарт, шаардлагын дагуу Цагаан суваргын ордын геологи хайгуул, техник технологийн бүрэн хэмжээний судалгаа шинжилгээний мэдээлэл дээр үндэслэгдсэн эдийн засгийн үр ашиг, хөрөнгө оруулалт, байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөөллийг тооцоолон тодорхойлсон баримт бичгийг хэлнэ;
- 17.2 “Цагаан суваргын төсөл” гэж Цагаан суваргын ордыг ашиглахтай холбогдсон уул уурхай, дэд бүтцийн бүтээн байгуулалт, гадаад, дотоод харилцаа, нийгэм эдийн засгийн болон бусад хамаарал бүхий үндсэн ба туслах үйл ажиллагааг;
- 17.3 “Цагаан суваргын үйлдвэр” гэж Техник, эдийн засгийн үндэслэлд дурдсан хүдрийн ил уурхай, жилд 14,6 сая хүдэр боловсруулж, 310,000 тонн зэсийн, 4,000 тонн молибдений баяжмал үйлдвэрлэх уулын баяжуулах үйлдвэрийг;
- 17.4 “Засгийн газар” гэж Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 3 дугаар

зүйлийн 3.1-д заасныг;

- 17.5 “Төслийн компани” гэж хөрөнгө оруулалтын гэрээ байгуулахаар хүсэлт гаргасан Монгол Улсад үүсгэн байгуулагдсан, улсын бүртгэлийн 9011465103 дугаар, ашигт малтмалын 9630А тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийг эзэмшигч “Эрдэнэс Цагаан Суварга” ХХК-г болон түүний эрх үүргийг шилжүүлэн авсан этгээдийг;
- 17.6 “Хөрөнгө оруулагч” гэж Төслийн компанид хөрөнгө оруулах замаар хувьцаа эзэмшиж буй этгээдийг;
- 17.7 “Төслийн үйл ажиллагаа” гэж Цагаан суваргын хүдрийн ил уурхай, уулын баяжуулах үйлдвэр, дэд бүтцийн барилга байгууламжийг барьж байгуулах, тэдгээрийг ажиллуулах, дагалдах түүхий эдийг эрэх, хайх, газрын гадаргуу болон түүний хэвлийгээс ялган авах, олборлох, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулах, түүнчлэн үйлдвэр уурхайг хаах, байгаль орчны нөхөн сэргээлт хийх асуудлыг шийдвэрлэх зэрэг Цагаан суваргын үйлдвэрийн төсөлтэй холбоотой Төслийн компани болон Хөрөнгө оруулагч, гэрээлэгч бусад этгээдийн бүхий л төрлийн үйл ажиллагааг;
- 17.8 “Татварыг үл ялгаварлах зарчмаар ногдуулах” гэж татварын болон бусад эрх бүхий байгууллагаас ногдуулсан татвар, түүний хувь хэмжээ, татварын шаардлага нь бусад аж ахуйн нэгж, компани, татвар төлөгчдөд ногдуулж буй татвараас илүүгүй хувь хэмжээгээр ногдуулсан, тооцсон аргачлал нь ижил бөгөөд эрх зүйн байдлыг дордуулаагүй, татварын дарамт учруулахгүй байхыг;
- 17.9 “Операторын үйлчилгээ үзүүлэх гэрээ (Operation and Maintenance(O&M))” гэж Төслийн компанийн зүгээс шинэ технологийг нутагшуулах, үйлдвэрийг хүчин чадал, төслийн үзүүлэлтэд хүргэх, үндэсний боловсон хүчинг сургаж дадлагажуулах зорилгоор шинээр байгуулагдсан үйлдвэр, уурхайн өдөр тутмын үйл ажиллагааг удирдах, технологийн шугам, техник, тоног төхөөрөмжийг ажиллуулах, тэдгээрт засвар үйлчилгээ хийлгэхээр гадаад, дотоодын мэргэжлийн баг хуулийн этгээдтэй байгуулсан гэрээг.

#### ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН  
ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ:

ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮН, УУЛ  
УУРХАЙН САЙД  
/Р.ЖИГЖИД/



“ЭРДЭНЭС ЦАГААН СУВАРГА”  
ХХК-ИЙГ ТӨЛӨӨЛЖ:

